

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

2025 оны 4 сарын 21 өдөр

№ 25/06

Улаанбаатар хот

НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

ГУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэг, “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.3.3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг болон 2025 оны 04 сарын 21-ний өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комисс саналыг кумулятив аргаар тоолсон болохыг тэмдэглэн, Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

- Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС /цаашид Сан гэх/-ийг үүсгэн байгуулах 2021 оны 06 сарын 03-ны өдрийн 21/009 тогтоолоор томилогдсон Сангийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд болох Н.Монсор, Ц.Батсүх, Ч.Анхбаяр нарыг 5 жилийн хугацаатай улируулан сонгосугай.
- Тогтоолын 1 дэх хэсэгт заасан улиран сонгогдож буй гишүүдийг олон нийтэд мэдээлэх, Зохицуулагч байгууллагуудад мэдэгдэхийг сангийн Гүйцэтгэх удирдлага Г.Ганзоригт даалгасугай.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга У.Сансармаад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.БАТЗОРИГ

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

2025 оны 4 сарын 21 өдөр

№ 25/07

Улаанбаатар хот

НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлж, нөхөн томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 10.2, 10.3 дахь хэсэг болон 2025 оны 04 сарын 21-ний өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комисс саналыг кумулятив аргаар тоолсон болохыг тэмдэглэн, Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

- Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС ХХК /цаашид Сан гэх/-ийн Нэгж эрх эзэмшигчдийн 2023 оны 04 сарын 22-ны өдрийн ээлжит хурлын 006 тоот тогтоолоор Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр томилогдсон Р.Амаржаргалын бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө буюу 2025 оны 04 сарын 21-ний өдрөөр дуусгавар болгосугай.
- Нэр дэвшүүлэх хорооноос дэвшүүлсэн Р.Сугархүүг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр 2025 оны 04 сарын 21-ний өдрөөс эхлэн 5 жилийн хугацаагаар томилсугай.
- Шинээр томиогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнийг олон нийтэд мэдээлэх, Санхүүийн Зохицуулах Хороонд тохиромжтой этгээдээр тодорхойлуулах, холбогдох бичиг баримтыг хүргүүлэхийг сангийн Гүйцэтгэх удирдлага Ганзоригт даалгасугай.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга У.Сансармаад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.БАТЗОРИГ